



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 22 өдөр

Дугаар A/305

Хэрлэн сум

Гэр бүлийн хэрэгцээнд дундаа
хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн нэг
гишүүнд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60.1.1 дэх заалт, Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэг, Газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн Засаг даргын 2008 оны 95 дугаар захирамжийн хавсралтын 82, 120 дахь дэс дугаараар тус тус гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа хамтран өмчилсөн иргэдийн өмчлөх эрх шилжүүлэх гэрээ болон бусад холбогдох бичиг баримтыг харгалзан хавсралтад дурдсан 2 иргэнд үнэ төлбөргүй шилжүүлэн өмчлүүлсүгэй.


2.Газар өмчлөгч иргэдийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч (Д.Эрдэнэбаатар)-д үүрэг болгосугай.

3.Хавсралтад дурдсан нэр бүхий иргэдэд хууль тогтоомжийн дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ





2025 оны 05 дугаар сарын 28 -ны
А/305 дугаар захирамжийн хавсралт

№	Өмчлөх эрх шилжүүлэн авч байгаа иргэний мэдээлэл				Хамтран өмчлөлөөс хасуулж, өмчлөх эрх нь сэргэж байгаа иргэний мэдээлэл				Захирамжийн талбарын дугаар		Хуучин нэгж	Газрын	
	Ургийн овог	Овог	Нэр	Регистрийн дугаар	Ургийн овог	Овог	Нэр	Регистрийн дугаар	Огноо	Дугаар		Байршил	Хэмжээ /м2/
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	Оорцог	Балзан	Калина	СТ68050414	Оорцог	Калина	Эрдэнэцэцэг	СТ90071206	2008-04-03	95	2311030664	5-р баг Сариг 5-02 тоот	971
					Оорцог	Калина	Энхтунгалаг	СТ91081004					
					Оорцог	Калина	Энхтогос	СТ93073004					
					Оорцог	Калина	Эрдэнэзул	СТ95012704					
					Оорцог	Калина	Хонгорзул	СТ01240619					
2	Боржигин	Ламзав	Нарангэрэл	СП70081300	Боржигон	Нарангэрэл	Энх-Оргил	СП90090435	2008-04-03	95	221601038	5-р баг Сариг 7-05 тоот	1119
					Боржигин	Нарангэрэл	Даваахүү	СП97012419					